



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТУШААЛ

2022 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт, ШУА-ийн дүрмийн 22 дугаар зүйлийн "в" дэх хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 299 дүгээр тогтоол, ШУА-ийн харьяа хүрээлэнгийн үлгэрчилсэн дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 299 дүгээр тогтоолоор байгуулагдсан ШУА-ийн Технологийн инкубаторын дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

2. Технологийн инкубаторыг удирдлага арга зүйгээр ханган ажиллахыг Эрдэмтэн нарийн бичгийн дарга (Б.Авид)-д даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Д.РЭГДЭЛ

Шинжлэх ухааны Академийн
Ерөнхийлөгчийн 2022 оны...
дугаар сарын ... өдрийн
А/ дугаар тушаалын хавсралт
/24

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ТЕХНОЛОГИЙН ИНКУБАТОРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Шинжлэх ухааны Академийн харьяа Технологийн Инкубатор /цаашид "Инкубатор" гэнэ/ нь Монгол Улсад шинжлэх ухаан, технологи, инновацийг хөгжүүлэх, улс орны нийгэм, эдийн засаг, оюуны хөгжлийн өмнө тулгамдсан асуудлыг орчин үеийн шинжлэх ухааны түвшинд судлан боловсруулах, шинэ мэдлэг, бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох, шинэ технологи, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, тэдгээрийг хөрөнгө оруулагчидтай холбож бизнесийн орчныг бүрдүүлэх, гарааны компаниудад эрх зүй, зохион байгуулалт, технологи, судалгаа хөгжүүлэлт, бизнесийн зөвлөгөө, дэмжлэг туслалцаа үзүүлэх, инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндсэн чиг үүрэг бүхий шинжлэх ухаан, технологи, эрдэм шинжилгээ, туршилт, үйлдвэрлэл, үйлчилгээний цогцолбор хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг эрдэм шинжилгээний мэргэжлийн төрөлжсөн байгууллага мөн.

1.2. Инкубатор үйл ажиллагаандаа Монгол улсын Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хууль, Инновацийн тухай хууль, ШУА-ийн дүрэм, Монгол Улсын бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

1.3. Инкубатор өдөр тутмын үйл ажиллагаагаа энэхүү дүрмийн дагуу боловсруулсан дотоод журмаар зохицуулна. Инкубаторын дүрэм, дотоод журмыг Инкубаторын бүх ажиллагсдын хурлаар тус тус хэлэлцэж, дүрмийг ШУА-ийн Ерөнхийлөгч, дотоод журмыг Инкубаторын захирал батална.

1.4. Инкубатор нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, банкны харилцах данс бүхий хуулийн этгээд мөн. Инкубаторын онцлогийг тусгасан бэлэгдэлтэй байна.

Хоёр. Инкубаторын үйл ажиллагааны зарчим, чиг үүрэг

2.1. Инкубаторын үндсэн зорилт нь шинэ технологи, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, тэдгээрийг хөрөнгө оруулагчидтай холбож маркетинг бизнесийн орчныг бүрдүүлэх, гарааны компаниудад эрх зүй, зохион байгуулалт, технологи, бизнесийн зөвлөгөө, дэмжлэг туслалцаа үзүүлэх, судалгаа-боловсруулалтын ажил эрхлэх, төсөл хэрэгжүүлэх, инновацийг бий болгож үр дүнг нэвтрүүлэх явдал мөн.

2.2. Инкубатор үйл ажиллагаандаа ардчилсан зарчим, хууль дээдлэх ёс, шинжлэх ухааны ёс зүй, бүтээлч хандлага, ил тод, хариуцлагатай шуурхай байдлыг удирдлага болгож захиргааны болон хамтын удирдлагын зарчмыг зохистой хослуулан хэрэгжүүлнэ.

2.3. Инкубатор нь дор дурьдсан үндсэн чиг үүрэг хэрэгжүүлнэ:

а/ шинэ технологи бойжуулах, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, технологийн туршилт зүгшрүүлэлт хийх, тэдгээрийг хөрөнгө оруулагчидтай холбож бизнесийн орчныг бүрдүүлэх, захиалгат болон судалгааны бусад төслүүдийг гүйцэтгэх замаар судалгаа-боловсруулалтын ажлын үр дүнг амьдрал практикт нэвтрүүлэх;

б/ бусад эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуульд хийгдэж байгаа судалгаа шинжилгээний болон сургалтын ажилд оролцох;

в/ олон улс, бүс нутаг, гадаад орнуудын болон дотоодын аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран судалгаа шинжилгээний ажил хийх, түүний үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, худалдах, патентлах;

г/ эрдэм шинжилгээний хурал, симпозиум, сургалт, семинар зохион байгуулах, ном бүтээл хэвлэх;

д/ зохих зөвшөөрлийн дагуу дангаараа болон бусад байгууллагатай хамтран туршилт-үйлдвэрлэлийн түшиц цех, нэгж байгуулах;

е/ эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үндэслэн төр, засгийн байгууллага, аж ахуйн нэгжид санал, зөвлөмж хүргүүлэх, үйл ажиллагааныхаа үр дүнг тогтоосон хугацаанд ШУА-ийн Тэргүүлэгчдийн газарт тайлагнах.

Гурав. Инкубаторын удирдлага, зохион байгуулалт

3.1. Инкубаторын хамтын удирдлагын хэлбэр нь эрдмийн зөвлөл, захиргааны зөвлөл байна. Захиргааны удирдлагыг захирал, менежер, салбар, нэгжийн эрхлэгч нар, мэргэжил, арга зүйн удирдлагыг төслийн удирдагчид хэрэгжүүлнэ.

3.2. Инкубаторын бүтэц, зохион байгуулалтын үндсэн нэгж нь алба, салбар байна. Ажлын онцлогоосоо хамааран үндсэн нэгж дотроо судалгаа туршилтын түшиц цех, гарааны компани зэрэг бусад нэгж байгуулж болно. Инкубаторын бүтцийг ШУА-ийн Тэргүүлэгчид батална.

Дөрөв. Эрдмийн зөвлөл

4.1. Эрдмийн зөвлөл нь Инкубаторын үйл ажиллагаа, эрдэм шинжилгээний ажлын чиглэлийг тодорхойлох, түүний явц, үр дүн, эрдмийн бүтээлийн талаар үнэлэлт, дүгнэлт өгөх, Инкубаторын захиралд зөвлөх чиг үүрэг бүхий хамтын удирдлагын хэлбэр болно.

4.2. Эрдмийн зөвлөлийг Инкубаторын захирал даргалах ба бүрэлдэхүүний тухай Инкубаторын саналыг ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж батална.

4.3. Инкубаторын эрдмийн зөвлөл нь тухайн Инкубаторын тэргүүлэх эрдэмтдээс бүрдэх бөгөөд бүрэлдэхүүний 25 хүртэл хувийг тухайн салбарын бусад эрдэмтэн судлаачид, холбогдох төр, орон нутгийн болон бизнесийн байгууллагын төлөөллөөс бүрдүүлж болно.

4.4. Эрдмийн зөвлөл дараах үүрэг хүлээж, эрх эдэлнэ:

а/ Инкубаторын үйл ажиллагаа, судалгааны тэргүүлэх чиглэлийг тогтоох, эрдэм шинжилгээний ажлын онол арга зүйн түвшин, ач холбогдол, үр дүнг хэлэлцэж санал дүгнэлт гаргах;

б/ Инкубаторын эрхэм зорилгыг тодорхойлж үйл ажиллагааны дунд хугацааны стратеги төлөвлөгөөг хэлэлцэн батлах;

в/ Хэрэгжүүлэх инновацийн, судалгаа, туршилт зүгшрүүлэлтийн зэрэг төслүүдийн саналыг хэлэлцэн дэвшүүлэх;

г/ үйл ажиллагаа, эрдэм шинжилгээний ажлын хөтөлбөр, төслийн явц, үр дүнгийн байдлыг хэлэлцэж үнэлгээ дүгнэлт өгөх, тэдгээрийн явц, гүйцэтгэлийн эцсийн үр дүнг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;

д/ технологи бойжуулалт, нутагшуулалт, туршилт зүгшрүүлэлт, нэвтрүүлэлт, гарааны компаний хөгжүүлэлт, эрдэм шинжилгээний ажлын тайланг хэлэлцэх;

е/ Инкубаторын дүрэм, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэн саналаа академийн тэргүүлэгчдэд хүргүүлэх;

ё/ Инкубаторын ажилтнуудын ажлын явц, үр дүн, туурвисан судалгааны бүтээлийг хэлэлцэж, хэвлэн нийтлэх талаар санал дүгнэлт гаргах;

ж/ эрдэм шинжилгээний ажилтанд бүтээлийн чөлөө олгох асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргах, үр дүнг хэлэлцэж дүгнэлт гаргах;

з/ эрдэм шинжилгээний ажилтнуудыг шагнаж урамшуулах, мэргэжил дээшлүүлэх асуудлыг хэлэлцэж зохих шийдвэр гаргах;

4.5. Эрдмийн зөвлөлийн ажиллах хэлбэр нь хуралдаан байна. Эрдмийн зөвлөлийн гишүүдийн 50-иас дээш хувь нь оролцсон тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцох ба хурлаас тогтоол, тэмдэглэл гаргана. Тогтоолд захирал, менежер гарын үсэг зурж баталгаажуулна.

Тав. Захиргааны зөвлөл

5.1. Захирлын бүрэн эрхээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргах, захиргааны шуурхай удирдлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй захиргааны зөвлөлийг ажиллуулна.

5.2. Захиргааны зөвлөл нь Инкубаторын захирал, менежер, салбар, нэгжийн эрхлэгч, шаардлагатай зарим төслийн удирдагч, санхүүгийн ажилтан зэрэг албан тушаалтнаас бүрдэнэ.

5.3. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг захирлын тушаалаар батална. Зөвлөлийг Инкубаторын захирал даргалах ба зөвлөл нь Инкубаторын ажлын шуурхай зохион байгуулалт, аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаа, ажиллагсдын нийгмийн баталгааны асуудлыг хэлэлцэж байна.

5.4. Захиргааны зөвлөл нь дараах асуудлыг хэлэлцэж, шийдвэр гаргана:

а/ Инкубаторын ажлын төлөвлөгөө;

б/ аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаа;

в/ ажлын байрны тодорхойлолт;

г/ ажиллагсдын нийгмийн баталгаа, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа;

д/ хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаатай холбоотой дүрэм, журам, заавар;

е/ сахилгын зөрчил, сахилгын арга хэмжээ;

5.5. Инкубаторын захирал тухайн жилийн батлагдсан төсөв түүний гүйцэтгэл зарцуулалтын талаар захиргааны зөвлөлд мэдээлж байна.

5.6. Захиргааны зөвлөлийн хурлаас хуралдааны тэмдэглэл гаргах ба шаардлагатай үед захирал тэмдэглэлийг үндэслэн тушаал гаргаж болно.

Зургаа. Инкубаторын захирал

6.1. Инкубаторын захирал нь Инкубаторын эрдэм шинжилгээ, хүний нөөц, захиргаа, санхүү, төсвийн зарцуулалт болон хамт олны өдөр тутмын үйл ажиллагааг шуурхай удирдлагаар хангаж, Инкубаторыг дотоод, гадаадад төлөөлнө. Инкубаторын үйл ажиллагааг эрдмийн хамт олон болон ШУА-ийн Ерөнхийлөгчийн өмнө хариуцна.

6.2. Захирлын эзгүй байх хугацаанд албан үүргийг нь Инкубаторын менежер орлон гүйцэтгэж болно. Түр орлосон албан тушаалтны шийдвэрийн хариуцлагыг захирал хүлээнэ.

6.3. Захирал нь дор дурьдсан үүрэг хүлээнэ:

- а/ Монгол улсын хууль тогтоомжийн дагуу тушаал, шийдвэр гаргаж, Инкубаторын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;
- б/ Инкубаторт мөрдөх журмуудыг боловсруулж батлуулах, мөрдүүлэх;
- в/ Инкубаторын албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан батлах, мөрдүүлэх, албан хаагчидтай хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээ, шаардлагатай тохиолдолд ажил гүйцэтгэх гэрээ байгуулах, биелэлтийг дүгнэх, цуцлах;
- г/ дотоодын шинжлэх ухааны болон бусад байгууллага, их, дээд сургуультай хамтран ажиллахад Инкубаторыг төлөөлж, хамтарсан судалгаа шинжилгээний ажлын үр ашиг, чанарыг дээшлүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг хангаж ажиллах;
- д/ ажиллагсдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авч, биелэлтийг хангаж ажиллах;
- е/ Инкубаторын гадаад харилцааны бодлогыг тодорхойлж гадаад орны эрдэм шинжилгээний байгууллагуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх;

6.4. Захирал нь Инкубаторыг төлөөлж дор дурьдсан эрх эдэлнэ.

- а/ дотоодын байгууллага, иргэдтэй харьцаж, хамтран гүйцэтгэх эрдэм шинжилгээний ажил, техник, технологи, ажил үйлчилгээний талаар гэрээ хэлцэл байгуулах;
- б/ Инкубаторын хөрөнгө, санхүүг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах;
- в/ Инкубаторын салбар, нэгжийн дарга, албан тушаалтан, ажиллагсдыг ажилд томилох, чөлөөлөх, шагнаж урамшуулах;
- г/ гадаад орны эрдэм шинжилгээний байгууллагуудтай ШУА-ийн Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр гэрээ, хэлцэл байгуулах;
- д/ хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх.

6.5. Захирал нь ШУА-ийн Ерөнхийлөгчтэй зөвшилцөж Инкубаторын менежерийг томилно.

6.6. Захирал нь ШУА-ийн Ерөнхийлөгчтэй хамтран ажиллах болон үр дүнгийн гэрээ байгуулж, Инкубаторын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж ажиллана.

6.7. Захирал нь Инкубаторын үйл ажиллагаа, ажлын онцлог, ажиллагсдын тоо, аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааны цар хэмжээнээс хамааран захиргаа, аж ахуй эрхэлсэн албан тушаалтантай байх асуудлаа ШУА-ийн Ерөнхийлөгчид тавьж шийдвэрлүүлнэ.

Долоо. Эрдэмтэн нарийн бичгийн дарга (Менежер)

7.1. Эрдэмтэн нарийн бичгийн дарга (Менежер) нь төлөвлөгөөт үйл ажиллагаа, эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлт, шинэ төсөл, технологи бойжуулалт, дамжуулалт, менежмент, маркетинг, туршилт зүгшрүүлэлтийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, гадаад дотоодын болон олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллах гэрээ хэлэлцээрийн биелэлтийг хангуулах салбар, нэгжүүдийн үйл ажиллагааг зохицуулах ба үйл ажиллагаа, эрдэм шинжилгээний ажлын нэгдсэн тайлан гаргах ажлыг зохион байгуулж, захирлын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, зөвлөх үүрэгтэй ажиллана.

Найм. Инкубаторын үндсэн салбар, нэгжийн эрхлэгч

8.1. Инкубаторын үндсэн салбар, нэгжүүдийн эрхлэгч нь судалгаа, туршилт зүгшрүүлэлтийн аль нэг төслийг удирдаж болох ба судалгааны төслүүдийг уялдуулан зохицуулах, эрдэм шинжилгээ, туршилт зүгшрүүлэлтийн ажлыг зохион байгуулах үүрэг хүлээнэ.

Ес.Эрдэм шинжилгээний болон бусад ажилтан

9.1. Эрдэм шинжилгээний болон бусад ажилтны сул орон тоонд захирал, тухайн үндсэн салбар, нэгжийн эрхлэгч, хамт олны хурлын саналыг харгалзан сонгон шалгаруулж авна.

9.2. Эрдэм шинжилгээний ажилтан, ажиллагсдын эрх, үүргийг холбогдох хууль, энэхүү дүрэм, дотоод журмаар зохицуулна.

9.3. Эрдэм шинжилгээний ажилтан 65 насанд хүрсэн боловч өөрөө хүсвэл түүний эрүүл мэндийн байдал, ажлын шаардлага, эрдмийн зөвлөлийн саналыг харгалзан гэрээт ажилтнаар ажиллуулж болно.

9.4. Эрдэм шинжилгээний ажилтан нь аттестатчилалд 4 жил тутамд хамрагдсан байна.

Арав. Санхүүжилт

10.1. Инкубатор нь улсын төсөв, эрдэм шинжилгээний ажлын суурь санхүүжилт, хэрэглээний судалгаа, туршилт зүгшрүүлэлтийн болон бусад төсөл хэрэгжүүлэх, үйл ажиллагааны орлого, бойжуулсан технологи, төсөл, бүтээгдэхүүний орлогоос ногдох хувь, дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, хандив тусламжийн хөрөнгө, гэрээгээр ажиллах зэрэг хуулиар зөвшөөрөгдсөн санхүүгийн бусад эх үүсвэрийг ашиглана.

10.2. Үйл ажиллагааны орлогыг нийгэм, соёл, шагнал урамшуулал, эрдэм шинжилгээ, технологи бойжуулалт, нутагшуулалт, хөгжүүлэлт, туршилт-зүгшрүүлэлтийн ажлыг санхүүжүүлэх, материал хангамж, аж ахуйн үйл ажиллагааг өргөтгөх хөрөнгө оруулалтад зохих журмын дагуу хуваарилан зарцуулна.

Арван нэг. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах

11.1. Инкубаторын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг Инкубаторын удирдлага, эрдэм шинжилгээний ажилтнууд гаргах эрхтэй бөгөөд уг саналыг захиргааны зөвлөл, эрдмийн зөвлөлийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, ШУА-ийн Тэргүүлэгчдэд тавьж шийдвэрлүүлнэ.

